Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	3.2	0.1	(3.1)
Банканд байгаа бэлэн мөнгө	6,666.0	7,932.6	1,266.6
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Хадгаламж	0.0	0.0	0.0
Дүн	6,669.2	7,932.7	1,263.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2,971.7	1,983.6	(988.1)
Төсөл/ сан	74.0	77.7	3.7
Төрийн сан	3,403.4	5,635.2	2,231.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	220.1	236.2	16.1
Дүн	6,669.2	7,932.7	1,263.5

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 7,932.6 сая төгрөгийн үлдэгдэлд гадаад валютаарх үлдэгдэл байхгүй байна. Үүнээс 1,983.6 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 77.7 сая төгрөг нь төсөл/сангийн, 236.1 сая төгрөг нь орон нутгийн өмчит байгууллагын, 5,635.2 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл байна.

Төсөвт байгууллагад бүртгэгдсэн 1,983.6 сая төгрөгийн 1,178.1 сая төгрөг нь орон нутгийн хөрөнгө оруулалтын, 709.1 сая төгрөг нь ОНХС-ийн, 96.4 сая төгрөг нь СХС-ийн үлдэгдэл бол төсөл, сангийн төрөлд бүртгэгдсэн 77.7 сая төгрөг нь байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн үлдэгдэл байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт дансны 1,178.1 сая төгрөг нь гүйцэтгэгч байгууллагуудын чанарын баталгааны барьцаа хөрөнгө бол ОНХС-ийн орлогын шилжүүлгийн 709.1 сая төгрөг нь тендерийн хэмнэлт болон ажлын гүйцэтгэл дутуу байгууллагуудад өгөх өр, мөн он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 7,932.6 сая төгрөгийн 97.0 хувь буюу 7,696.4 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 3.0 хувь буюу 236.2 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Касст байгаа 0.1 сая төгрөг нь “Ахмадын хороо” ТББ, “Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-уудын үлдэгдэл байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,403.4 сая, эцсийн үлдэгдэл 5,635.2 сая төгрөг болж, 2,231.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	3,403.4	5,635.2	2,231.8
Төгрөг	3,403.4	5,635.2	2,231.8
Төрийн сан	3,403.4	5,635.2	2,231.8
Монгол банк			
Арилжааны банк			
Гадаад валют			
Монгол банк			
Замд яваа хөрөнгө			
Нийт дүн	3,403.4	5,635.2	2,231.8

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвийн орлогоор 27,652.0 сая төгрөгийг бүрдүүлж, 23,118.1 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 655.7 сая төгрөгийг өмнөх оны татаас санхүүжилтийн өглөгт, 1,824.1 сая төгрөгийг аймгийн төсвөөс улсын төсөвт татан төвлөрүүлэх шилжүүлэгт зарцуулжээ.

Төрийн сангийн харилцахад байгаа 5,635.2 сая төгрөгийн 5,457.5 сая төгрөг нь аймаг, сумдын ерөнхий орлогын дансны үлдэгдэл, 177.7 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн зарцуулаагүй үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу байх, мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй илэрхийлэх, НДШ, ХХОАТ-ыг зөрүүтэй тооцох, нэмэлт санхүүжилтийн тайлан гаргаагүй байх зэрэг нийт 203.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 28.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /4 дүгээр сургууль 8.8 сая, 5 дугаар цэцэрлэг 2.0 сая, 12 дугаар сургууль 1.3 сая, 28 дугаар цэцэрлэг 2.3 сая, 24 дүгээр цэцэрлэг 2.3 сая, 9 дүгээр сургууль 1.8 сая, Ахмадын хороо 1.9 сая, 19-р цэцэрлэг 1.2 сая, Орхон тохижилт ОНӨААТҮГ 2.4 сая/
- Хонгор сумын ЗДТГ, ЭМТ, Амин холбоо өрхийн эмнэлэг, 6, 8, 26 дугаар цэцэрлэгүүд, 1, 4, 11 дүгээр сургуулиуд мөнгөн гүйлгээний тайланг 148.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- 8, 25 дугаар цэцэрлэг НДШ, ХХОАТ-ыг зөрүүтэй тооцсон 2.3 сая,
- Орхон сумын төсөвт байгууллагууд 8.5 сая төгрөгийн цалин, тэтгэмж, илүү тооцож олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 172.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 5.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 21.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 2,749.0 сая төгрөгөөс тайлант онд 647.9 сая төгрөгөөр өсөж, оны эцэст 3,396.9 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Хүснэгт №3. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	293.2	228.5	(64.7)
Татаас, санхүүжилтийн авлага	13.2	0.0	(13.2)
Зээлийн хүүгийн авлага	9.6	9.9	0.3
Дансны авлага /ТӨҮГ/	660.1	846.1	186.0
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	21.7	49.0	27.3
Байгууллагаас авах авлага	80.1	384.2	304.1
Хувь хүмүүсээс авах авлага	1,671.1	1,879.2	208.1
Дүн	2,749.0	3,396.9	647.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,717.3	2,162.6	445.3
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	33.6	33.6	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	998.1	1,200.7	202.6
Дүн	2,749.0	3,396.9	647.9

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 35.3 хувь буюу 1,200.7 сая төгрөг нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт, 1.0 хувь буюу 33.6 сая төгрөг нь төрийн санд, 63.7 хувь буюу 2,162.6 сая төгрөг нь төсөвт байгууллагад байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд дахь нийт авлагын 1,103.5 сая төгрөг буюу 91.9 хувийг “Дархан Ус суваг” ОНӨХК-ний авлага эзэлж байна.

Харин төсөвт байгууллагууд дахь нийт авлагын 1,797.7 сая төгрөг буюу 83.1 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага эзэлж байгаа бөгөөд тайлант онд шинээр 730.4 сая төгрөгийн зээлийг тус сангаас олгожээ.

Авлагын нийт үлдэгдэлд 1,135.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байгаа бөгөөд үүнээс 838.9 сая төгрөг нь ОНӨААН-ийн дансны авлага, 278.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага, 16.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын дансны авлагын үлдэгдэл байна.

Эдгээр нь авлага найдваргүй болж, төсвийн хөрөнгө үрэгдэх, удирдлага болон санхүүгийн ажилтан хариуцлага хүлээх үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй байх, илүү мөнгө шилжүүлж авлага үүсгэх, буруу бүртгэх, авлагыг бүртгэлгүй орхигдуулах, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зэргээс 100.0 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Орхон сумын СХС 51.0 сая, Дархан сумын ЗДТГ 16.5 сая, Шарын гол сумын ЗДТГ 1.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад анхаарч ажиллаагүй,
- Амин холбоо өрхийн эмнэлэг 4.4 сая төгрөгийн НДШ-ийн илүү төлөлтийг авлагаар тусгаагүй,
- Оюуны ирээдүй цогцолбор сургууль 1.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- 6 дугаар цэцэрлэг 1.1 сая төгрөгийн татвар илүү шилжүүлсэн,
- 5 дугаар цэцэрлэг 2.9 сая төгрөгийн авлагын дансны бичилт буруу хийсэн,
- БОАЖГ өмнөх оны авлагыг орлогоор бүртгэсэн 1.5 сая төгрөг,
- Шарын гол сумын ЗДТГ 8.5 сая төгрөгийн авлага, өглөгийг илүү бүртгэсэн,
- Орхон сумын Соёлын төв 1.5 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй,
- Дархан автозам тээвэр ОНӨААТҮГ 5.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 5.5 сая төгрөгийн авлагыг бүртгэлд тусгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 13.0 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 21.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 64.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 315.2 сая төгрөгөөс эцсийн үлдэгдэл 89.3 сая төгрөг болж, 225.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	315.2	89.3	(225.9)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0	0.0
Томилолтын урьдчилгаа	0.0	0.0	0.0
Дүн	315.2	89.3	(225.9)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	33.5	0.0	(33.5)
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	281.7	89.3	(192.4)
Дүн	315.2	89.3	(225.9)

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсөвт байгууллагын 33.5 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардлыг тайлант хугацаанд зардлаар бүртгэсэн байна.

Орон нутгийн өмчит газрын урьдчилж төлсөн зардал нь “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр бөгөөд тайлант онд 192.4 сая төгрөгөөр бууруулж ажилласан байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд урьдчилгаа данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 4,661.3 сая төгрөг байснаас оны эцэст 5,818.6 сая төгрөг болж, 1,157.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	859.9	1,317.2	457.3
Бэлэн бүтээгдэхүүн	1.0	14.5	13.5
Хангамжийн материал	3,756.6	4,296.3	539.7
Мал амьтад	43.8	190.6	146.8
Дүн	4,661.3	5,818.6	1,157.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4,053.5	4,826.4	772.9
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	607.8	992.2	384.4
Дүн	4,661.3	5,818.6	1,157.3

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн 17.0 хувийг ОНӨААТҮГ, 83.0 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

Бараа материалын үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- БСШУЯ-аас ерөнхий боловсролын сургуулиудад хөрөнгө оруулалтаар 267.9 сая төгрөгийн түрээсийн ном, хичээлийн хэрэглэгдэхүүн, кабинетын багаж хэрэгсэл ирсэн,

- Өрхийн эмнэлгүүд болон төсөвт байгууллагууд ковид халдварт өвчинтэй холбогдуулан 190.9 сая төгрөгийн ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэл, эм боох материал худалдан авсан,

- Аймгийн ЗДТГ-т 148.4 сая төгрөгийн өндөр ашиг шимт үүлдрийн мал худалдан авсан,

- “Дархан ус суваг” ОНӨХК шинэ хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын 111.8 сая төгрөгийн материал үлдэгдэлтэй,

- Сумдын ЗДТГ 62.2 сая төгрөгийн бараа материалыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан,

- 2 цэцэрлэг шинээр байгуулагдсанаар 50.2 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл, тайлагнал, тооллого, анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой 200.0 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн 21.7 сая /Дархан сумын ЗДТГ 10.9 сая, Дархан сумын ИТХ 1.9 сая, 22 дугаар цэцэрлэг 2.1 сая, 24 дүгээр цэцэрлэг 2.1 сая, Захирагчийн алба 1.7 сая/
- Дархан сумын ЗДТГ 85.2 сая, Орхон сумын ЗДТГ 4.3 сая төгрөгөөр бараа материалыг буруу ангилан бүртгэсэн,
- Материалыг дутуу тайлагнасан 28.2 сая /11 дүгээр цэцэрлэг 17.1 сая, Түвшин холбоо өрхийн эмнэлэг 1.2 сая, Хонгор сумын ИТХ 9.4 сая, Орхон сумын 9 дүгээр цэцэрлэг 2.9 сая/,
- Бараа материалын тооллого хийгээгүй 6.4 сая /6 дугаар цэцэрлэг 2.2 сая, 12 дугаар сургууль 3.0 сая, 16 дугаар цэцэрлэг 1.2 сая/
- БОАЖГ-ын бараа материал 7.2 сая төгрөгөөр тооллогын бүртгэлээс зөрүүтэй,
- Бараа материалыг бүртгээгүй 20.8 сая /18 дугаар цэцэрлэг 19.3 сая, 15 дугаар сургууль 0.8 сая, Дархан сумын СХС 0.7 сая/,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 19.8 сая /25 дугаар цэцэрлэг 1.1 сая, 14 дүгээр цэцэрлэг 1.1 сая, Шарын гол сумын ЭМТ 9.3 сая, Тулга сувилал 7.2 сая/

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 172.3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 7.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 19.8 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 264,699.5 сая төгрөг байснаас тайлант онд 4,275.2 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 268,974.7 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	125,846.8	122,783.9	(3,062.9)
Авто тээврийн хэрэгсэл	2,551.0	2,479.7	(71.3)
Машин тоног төхөөрөмж	6,366.7	7,830.3	1,463.6
Тавилга эд хогшил	1,942.7	2,455.9	513.2
Зам гүүрийн байгууламж	41,747.9	45,049.1	3,301.2
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	25.0	62.3	37.3
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	568.4	603.8	35.4
Бусад үндсэн хөрөнгө	14,302.1	16,008.9	1,706.8
Дуусаагүй барилга байгууламж	10,670.2	10,665.3	(4.9)
Номын фонд	1,143.6	1,165.0	21.4
Программ хангамж	115.7	89.9	(25.8)
Бусад биет бус хөрөнгө	59,417.8	59,779.0	361.2
Биологийн хөрөнгө	1.6	1.6	0.0
Дүн	264,699.5	268,974.7	4,275.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	185,783.1	190,845.4	5,062.3
Төсөл/сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	78,916.4	78,129.3	(787.1)
Дүн	264,699.5	268,974.7	4,275.2

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 68,594.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс 741.1 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 11,000.4 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар, 48,548.2 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст болон бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 5,017.4 сая төгрөгийн хөрөнгийг бусад эх үүсвэрээр авч, 3,287.7 сая төгрөгөөр дахин үнэлгээний зөрүү данс нэмэгдсэн байна.

2020 онд 54,746.5 сая төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсанаас эрх бүхий байгууллагын шийдвэрээр 6,098.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 46,132.7 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр, 220.5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн, 42.7 сая төгрөгийн хөрөнгийг худалдаж, 2,252.3 сая төгрөгийн хөрөнгийг бусад шалтгаанаар хасаж, тайлант хугацаанд 14,509.2 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Тайлант онд үндсэн хөрөнгө нэмэгдсэн гол шалтгаан нь 13 дугаар цэцэрлэг 984.8 сая, 6 дугаар цэцэрлэг 974.9 сая төгрөгийн өргөтгөлийн барилга орлогод авсан, 18 дугаар сургууль дээвэр болон гадна биеийн тамирын талбайд хийсэн 139.7 сая төгрөгийн их засварыг капиталжуулсан, 16 дугаар сургууль улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 267.5 сая төгрөгийн биеийн тамирын талбай, 5 өрхийн эмнэлэг улс, орон нутгийн төсөв болон ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бий болсон 265.4 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.

Шинээр ашиглалтад орсон 29 дүгээр цэцэрлэг 1,517.9 сая, 30 дугаар цэцэрлэг 75.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэсэнээр мөн үндсэн хөрөнгө нэмэгджээ.

Дуусаагүй барилгын дансанд 10,665.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Биеийн тамир спортын газарт 10,585.8 сая, Шарын гол сумын ЗДТГ-т 79.5 сая төгрөгийн хөрөнгө байна.

Монгол Улсын Засгийн газар, БСШУ-ны яамны захиалгаар улсын төсвийн санхүүжилтээр Дархан-Уул аймагт баригдаж буй “Спорт цогцолбор”-ын барилга 2011 онд эхэлсэн бөгөөд технологийн өөрчлөлт, барилгын материалын үнийн өсөлт зэргийн нөлөөнөөс анхны төсөвт өртөг нь өссөнөөс царцаагдаж, одоогоор ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Энэхүү хөрөнгийн ажлын гүйцэтгэл 10,585.8 сая төгрөг нь Биеийн тамир спортын газарт бүртгэгджээ.

Шарын гол сумын ЗДТГ-ын дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй 79.5 сая төгрөгийн барилгын ажил дуусаж, ашиглагдаж байгаа ч барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгээгүй тул төсвийн шууд захирагчийн аудитаар зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ангилал буруу бүртгэсэн, дансны бичилтийг буруу хийсэн, хөрөнгийг орлого аваагүй, давхардуулан бүртгэсэн, тайланг буруу илэрхийлсэн, дахин үнэлгээг зөрүүтэй бүртгэсэн, дахин ашиглах боломжтой 0 үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлээгүй, дахин үнэлгээтэй холбоотой дансны бичилтийг буруу хийсэн, элэгдлийг зөв тооцоогүй, худалдан авалтын гэрээг дүгнээгүй, тооллого хийгээгүй, хөрөнгийг зардлаар бүртгэсэн зэрэг үндсэн хөрөнгийн данстай холбоотой 10,483.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ 4,024.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Үндсэн хөрөнгөтэй холбоотой 37.9 сая төгрөгийн бичилтийг буруу хийсэн /ДХББЗГ ОНӨААТҮГ 13.2 сая, 11 дүгээр сургууль 24.7 сая/,
- НААҮГ 952.9 сая төгрөгийн мод бут, ногоон байгууламжийг түүх соёлын дурсгалт зүйлээр бүртгэсэн,
- Дахин үнэлэх хөрөнгийг үнэлээгүй 2,375.7 сая /Түвшин холбоо өрхийн эмнэлэг 13.0 сая, 3 дугаар цэцэрлэг 22.8 сая, 18 дугаар сургууль 239.5 сая, Дархан сумын ИТХ 8.9 сая, Госхот өрхийн эмнэлэг 62.2 сая, 23 дугаар цэцэрлэг 19.5 сая, 13 дугаар цэцэрлэг 109.8 сая, 1 дүгээр сургууль 109.7 сая, 4 дүгээр сургууль 379.4 сая, Сум дундын ойн анги 8.9 сая, Орон нутгийн өмчийн газар 21.7 сая, Тулга сувилал 28.2 сая, Шарын гол сумын Соёлын төв 23.0 сая, 6 дугаар сургууль 963.7 сая, 2 дугаар сургууль 263.5 сая, 2 дугаар цэцэрлэг 34.1 сая, Хонгор сумын Соёлын төв 4.1 сая, Хонгор сумын ЭМТ 62.5 сая, Орхон сумын ЭМТ 25.8 сая, 8 дугаар сургууль 111.7 сая/,
- Дахин үнэлгээтэй холбоотой дансны бичилтийг хийгээгүй, эсвэл буруу хийсэн 858.8 сая / Дархан орон нутгийн зам тээвэр ОНӨААТҮГ 155.5 сая, 6 дугаар цэцэрлэг 3.2 сая, Оюуны ирээдүй цогцолбор сургууль 285.1 сая, 12 дугаар цэцэрлэг 23.6 сая, 1 дүгээр

цэцэрлэг 19.7 сая, 4 дүгээр цэцэрлэг 17.1 сая, 8 дугаар цэцэрлэг 336.1 сая, 16 дугаар цэцэрлэг 14.7 сая, 1 дүгээр сургууль 2.6 сая, Сум дундын ойн анги 1.1 сая/

- Элэгдлийн зардлыг зөв тооцоогүй 1,606.1 сая /7 дугаар цэцэрлэг 57.3 сая, НААҮГ 1,374.5 сая, 15 дугаар цэцэрлэг 61.2 сая, 1 дүгээр сургууль 13.3 сая, 4 дүгээр сургууль 93.8 сая, Хонгор сумын соёлын төв 3.9 сая/
- НААҮГ 94.9 сая төгрөгийн худалдан авалтын гэрээг дүгнээгүй,
- 25 дугаар цэцэрлэг тооллого хийгээгүй, ГБХЗХГ тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн,
- 15 дугаар сургууль 6.5 сая, 22 дугаар цэцэрлэг 10.1 сая төгрөгийн хөрөнгийг зардлаар бүртгэсэн,
- Шарын гол сумын ЭМТ 139.8 сая төгрөгийн тооллого хийгээгүй,
- Орхон тохижилт ОНӨААТҮГ 226.4 сая төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгийг буруу ангилж бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 7,737.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулаа хийлгэж, 105.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 2,640.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 40,650.9 сая төгрөг байснаас оны эцэст 44,885.9 сая төгрөг болж, 4,235.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u>	39,983.2	44,484.4	4,501.2
Богино хугацаат зээлийн өглөг	33,968.9	40,396.3	6,427.4
Ажилчидтай холбогдсон өглөг	71.0	13.9	(57.1)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	356.7	0.0	(356.7)
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	2,423.8	1,178.1	(1,245.7)
Бусад өглөг	3,146.0	2,885.7	(260.3)
Урьдчилж орсон орлого	16.8	10.4	(6.4)
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>	667.7	401.5	(266.2)
Урт хугацаат зээлийн өглөг	667.7	401.5	(266.2)
Нийт дүн	40,650.9	44,885.9	4,235.0
<u>Үүнээс, байгууллагын төрлөөр</u>			
Төрийн сан	33,969.2	40,396.3	6,427.1
Төсөвт байгууллага	4,035.2	2,002.3	(2,032.9)
ТӨҮГ болон ОНӨҮГ	2,646.5	2,487.3	(159.2)
Дүн	40,650.9	44,885.9	4,235.0

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн өсөлт нь Азийн хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжиж байгаа “Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төслийн” зээлийн өглөг 6,427.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 1,188.2 сая төгрөгийн барьцаа, 40,396.3 сая төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээл, 2,899.9 сая төгрөгийн бусад өр байна.

Барьцаа дансанд хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн чанарын баталгааны барьцаа 1,178.1 сая, сумдын байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа 10.1 сая төгрөгийн өр төлбөр байна.

Бусад өр төлбөрийн 2,899.9 сая төгрөгийн үлдэгдэлд дансны болон татвар, нийгмийн даатгалын шимтгэл, ноогдол ашиг, урьдчилж орсон орлогын 2,085.8 сая төгрөгийн ОНӨААН-ийн, байгууллага, хувь хүмүүст төлөх болон ажилчидтай холбогдсон 239.0 сая төгрөгийн төсөвт байгууллагын, ажлын гүйцэтгэл дутуу байгууллагуудад өгөх 575.1 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн өр байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд “Дархан Ус суваг” ОНӨХК-ийн хөрөнгө оруулалт, их засварын эх үүсвэр дутагдсан шалтгаанаар 667.7 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөг тайлант онд 266.2 сая төгрөгөөр буурч, 401.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэх, өр төлбөрийг бүртгэлгүй орхигдуулах зэргээс 109.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Дархан сумын ОНХС 50.4 сая төгрөгийн дансны өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй,
- 14 дүгээр сургууль 22.0 сая, 11 дүгээр сургууль 23.5 сая, Хонгор сумын ИТХ 4.6 сая, Хонгор сумын Соёлын төв 4.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 0.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 109.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 238,477.7 сая төгрөг байснаас тайлант онд 2,918.6 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 241,396.3 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	96,016.2	96,247.0	230.8
Өмч /ТӨҮГ/	22,489.5	22,489.5	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	41,076.1	46,723.0	5,646.9
Хуримтлагдсан үр дүн	(30,898.1)	(35,757.7)	(4,859.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	109,794.0	111,694.5	1,900.5
Нийт дүн	238,477.7	241,396.3	2,918.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төрийн сан	(32,229.8)	(35,084.6)	(2,854.8)
Төсөл/сан	0.0	0.0	0.0
Төсөвт байгууллага	192,329.9	198,320.7	5,990.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	78,377.6	78,160.2	(217.4)
Нийт дүн	238,477.7	241,396.3	2,918.6

Эх сурвалж: Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн “Засгийн газрын оруулсан капитал” данс 1 цэцэрлэг шинээр ашиглалтад орсноор 115.6 сая, “Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар” барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулах газар авснаар 55.2 сая, Орон нутгийн өмчийн газар 2018 онд бүртгэсэн газрын үнэлгээг залруулснаар 60.0 сая төгрөгөөр эх үүсвэр тус тус нэмэгдсэн байна.

“Эздийн өмчийн бусад хэсэг” дансны өсөлтөд “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-т шинээр ашиглалтад хүлээн авсан 5,014.0 сая төгрөгийн автозам, авто зогсоол, замын тэмдэг, “Мэдээлэл технологийн алба” ОНӨААТҮГ-т 180.6 сая төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, Ахмадын хороонд хандиваар өгсөн 25.6 сая төгрөгийн хөрөнгө, “Эмтнаран” ОНӨААТҮГ-т 159.4 сая төгрөгийн барилга, тоног төхөөрөмж, “Дархан Ус суваг” ОНӨХК-д Турк улсын Тика ОУБ-ын буцалтгүй тусламжаар 40.8 сая төгрөгийн ус түгээх худаг, мөн “Орхон тохижилт” ОНӨААТҮГ-т 226.5 сая төгрөгийн хогны машин, цэвэр бохир усны инженерийн шугам хоолой зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр бүртгэсэн нь нөлөөлжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны өсөлтөд “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд НААҮГ-ын нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, байгууламжийг дахин үнэлснээр 1,844.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд цэвэр хөрөнгө, өмчтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

3.5.8 Орлогын данс

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 6,126.4 сая, туслах үйл ажиллагааны орлого 5,030.4 сая төгрөгөөр илэрхийлэгджээ.

Үндсэн үйл ажиллагааны орлогын 5,720.4 сая төгрөг буюу 93.4 хувийг, туслах үйл ажиллагааны орлогын 4,872.7 сая төгрөг буюу 96.9 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн орлого эзэлж байна.

“Дархан ус суваг” ОНӨХК тайлант онд 31 дүгээр хорооллын инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг гүйцэтгэн, 4,860.0 сая төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого олсон байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар орлогыг тусгалгүй орхигдуулах, илүү бүртгэх, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй байх, орлого үр дүнгийн тайланг зөрүүтэй бэлтгэх зэрэг 4,221.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Шарын гол сумын ерөнхий орлогын дансанд 3,916.0 сая төгрөгийн тусгай зориулалтын ишлжүүлгийн орлогыг тусгаагүй,
- Хонгор сумын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч ажиллаагүйгээс төлөвлөгөөг 239.4 сая төгрөгөөр тасалдуулсан,
- 18 дугаар сургууль 57.6 сая төгрөгөөр үр дүнгийн тайланг зөрүүтэй бэлтгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 3,982.4 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 239.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.5.9 Зардлын данс

Аудитын илрүүлэлт:

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалин, нэмэгдэл хөлсийг илүү олгох, цалингийн сүлжээг буруу тогтоох, тушаал шийдвэргүйгээр цалингийн нэмэгдэл олгох, батлагдаагүй орон тоонд ажил хавсруулах, тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албаны цалингийн сүлжээгээр цалинжуулах, цалингийн зардлаас НДШ төлөх, зардлыг дутуу тайлагнах, зардлыг ангилал зөрүүлэн бүртгэх, зарцуулалтын тайланг баталгаажуулаагүй байх, шаардах хуудас дугаарлалтгүй, хандив өгөх, ОНӨААН бизнес төлөвлөгөөг алдагдалтай батлуулах зэрэг 3,257.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- “Дархан Ус суваг” ОНӨХК бизнес төлөвлөгөөгөө 3,115.9 сая төгрөгийн алдагдалтай батлуулсан, 10.7 сая төгрөгийн хандив өгсөн,
- 7 байгууллага тэтгэвэр тогтоолгосон ажилтныг төрийн албаны цалингаар цалинжуулсан 68.2 сая төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 11.6 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 15.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 91.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 3,139.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 28,699.7 сая төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг 2,267.4 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар давж биелснээс татварын орлого 2,036.8 сая төгрөгөөр, татварын бус орлого 230.6 сая төгрөгөөр тус тус давсан байна.

Хүснэгт №9. Орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	23,279.5	25,316.3	2,036.8	108.7
Татварын бус орлого	3,152.8	3,383.4	230.6	107.3
ОНХС-ийн орлогын шилжүүлэг	6,423.7	6,380.9	(42.8)	99.3
Тусгай зориулалтын шилжүүлэг	41,790.6	41,790.6	0.0	100.0
НДС-аас санхүүжих	181.0	164.8	(16.2)	91.0
ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого	112.6	9.2	(103.4)	8.2
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,291.8	152.5	(3,139.3)	4.6
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	78,232.0	77,197.7	(1,034.3)	98.7

Давсан орлогын шалтгааныг авч үзвэл:

- **Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого:** Нийгмийн даатгалын хэлтэс болон Татварын албаны тоон мэдээллийг тулган тандалт хийснээр татвар төлөгчдийн тайлагналыг баталгаажуулж, татвар төлөхөөс зайлсхийхээс сэргийлэх арга хэмжээ авснаар тус орлого 1,397.7 сая төгрөгөөр,

- **Бусад орлого:** “Эрдэнэс-таван толгой” ХК-ий хувьцааны ногдол ашгийн татвар тайлант оны эцэст орж ирснээс 606.8 сая төгрөгөөр,

- **Үл хөдлөх хөрөнгийн татварын орлого:** Улсын бүртгэлийн хэлтэстэй үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг тулган баталгаажуулж хамтран ажилласны үр дүнд 275.8 сая төгрөгөөр,

- **Хүү, торгуулийн орлого:** Хууль, хяналтын байгууллагууд болон замын цагдаагийн ажлын хүрээнд хийгдсэн хүү, торгууль, актын барагдуулалтыг эрчимжүүлснээр 79.5 сая төгрөгөөр,

- **Бусад нэр заагдаагүй орлого:** Тайлант онд орон нутгийн өмч түрээслүүлсний орлого болон орон нутгийн өмчид бүртгэлтэй орон сууц дуудлага худалдаагаар борлуулсны орлого 94.2 сая төгрөгөөр тус тус давж биелжээ.

Харин татварын орлого нийт дүнгээр биелсэн боловч улсын тэмдэгтийн хураамж 21.2, газрын төлбөр 4.6, газрын дуудлага худалдааны орлого 30.5, ус рашаан ашигласны төлбөр 11.9 хувиар тус тус тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- **Улсын тэмдэгтийн хураамж:** Төрийн байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарласнаас орлого 98.0 сая төгрөгөөр,

- **Газрын төлбөр:** Газрын төлбөрийн барагдуулалтад анхаарч ажиллаагүйгээс Хонгор сумын орлого 64.9 сая, Дархан сумын орлого 158.2 сая төгрөгөөр дутуу биелж, нийт гүйцэтгэл 60.1 сая төгрөгөөр,

- **Газрын дуудлага худалдааны орлого:** 11 нэгж талбарт газрын дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч оролцогч ирээгүйгээс дуудлага худалдаа амжилтгүй болж, орлого 61.0 сая төгрөгөөр,

- **Ус рашаан нөөц ашигласны төлбөр:** Цар тахлын улмаас ААН, төрийн байгууллагын үйл ажиллагааг хязгаарласан, “ДДЦС” ТӨХК-д техникийн саатал, эвдрэл гарснаас усны хэрэглээ буурсан зэрэг шалтгаанаар орлого 74.3 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

2020 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 1,824.1 сая төгрөгийн төвлөрүүлэлтийг 100 хувь төвлөрүүлжээ.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн ИТХ-ын 2019 оны 15/07 дугаар тогтоолоор аймгийн төсвийн суурь орлогыг төсвийн төслөөс 6,776.2 сая, УИХ-аас хянаж ирүүлсэн суурь орлогоос 4,393.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан нь өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурласан байна.

Төсвийн жилийн дундуур Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Дархан-Уул аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 22,707.9 сая төгрөгөөр бууруулж тодотгожээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 18/01 дүгээр тогтоолоор суурь орлогыг анх баталсан төсвөөс 1,382.8 сая төгрөгөөр бууруулсан бол УИХ-ын тодотгон баталсан суурь орлогыг 3,770.3 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Төсвийн гүйцэтгэл

Аймгийн орон нутгийн 2020 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 78,232.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 72,685.3 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 92.9 хувьтай гарчээ.

Хүснэгт №10. Зардлын гүйцэтгэл үлдээгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урсгал зардал	65,148.4	61,212.2	(3,936.2)
Хөрөнгийн зардал	12,175.5	10,742.7	(1,432.8)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	908.1	730.4	(177.7)
Нийт зарлагын дүн	78,232.0	72,685.3	(5,546.7)

Орон нутгийн төсвийн урсгал зардал 61,212.2 сая төгрөг буюу 94.0 хувь, хөрөнгийн зардал 10,742.7 сая төгрөг буюу 88.2 хувийн гүйцэтгэлтэй гарчээ. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 730.4 сая төгрөг буюу 80.4 гүйцэтгэлтэй гарч, өнгөрсөн оноос 111.6 сая төгрөгөөр буурахад Дархан сумын СХС-ийн 75.4 сая төгрөг зарцуулаагүй үлдсэнээс шалтгаалжээ.

Урсгал зардлын гүйцэтгэлд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал 68.2 хувийг эзэлж байгаа бөгөөд зардлын гүйцэтгэл 97.3 хувьтай гарсан бол орон нутгийн төсөвт байгууллагуудын зардал 31.2 хувийг эзэлж, зардлын гүйцэтгэл 87.4 хувьтай гарсан байна.

Засгийн газрын 2020 оны 78 дугаар тогтоолоор хэмнэлтийн горимд шилжүүлж, цалин, тэтгэвэр тэтгэмжээс бусад зардлыг тэвчих, Ковид-19 халдварын улмаас зарим байгууллагын үйл ажиллагааг хязгаарласнаас шалтгаалан урсгал зардал 3,936.2 сая төгрөгийн хэмнэгдсэн байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагааг зогсоосноор нормативт зардал 1,061.8 сая төгрөгөөр,
- Оны эцэст төсөв захирагч нарын хэмнэгдсэн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөд нэмж баталснаар бараа, үйлчилгээний бусад зардал 679.7 сая төгрөгөөр,
- Засаг даргын ерөнхий данснаас махны нөөц бэлтгэх зардлыг 400.0 сая төгрөгөөр тодотгосон, сургуулийн хүүхдийн автобус, нийтийн тээвэрт олгох татаас 353.6 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжсэн нь урсгал зардлын гүйцэтгэл буурахад нөлөөлжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 218 төсөл, арга хэмжээнд 6,114.0 сая төгрөг баталж, гүйцэтгэл 90 хувьтай, ОНХС-ийн хөрөнгөөр 110 төсөл, арга хэмжээнд 5,921.4 сая төгрөг баталж, гүйцэтгэл 87.9 хувьтай байна.

Хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөгөөнөөс 608.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь гүйцэтгэгч байгууллагад олгох баталгаат хугацааны барьцаа 28.7 сая төгрөг, он дамжин хэрэгжиж байгаа 6 төсөл, арга хэмжээний 341.9 сая төгрөг, хэрэгжээгүй

7 ажлын 103.6 сая төгрөг, тендерийн хэмнэлт 80.3 сая төгрөг, ажлын гүйцэтгэл болон бичиг баримт хангалтгүй шалтгаанаар комисс хүлээн аваагүй 53.9 сая төгрөг үлджээ.

Хэрэгжээгүй 103.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний 33.6 сая төгрөгийн 3 ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бол 50.0 сая төгрөгийн зураг төсвийн ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн, 20.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний тендерт оролцогч ирээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн гүйцэтгэлийг 802.6 сая төгрөгөөр дутуу олгосон нь гүйцэтгэгч байгууллагад олгох баталгаат хугацааны барьцаа 88.6 сая, он дамжин хэрэгжиж байгаа 4 төсөл, арга хэмжээний 133.8 сая, хэрэгжээгүй 5 ажлын 141.4 сая, тендерийн хэмнэлт 68.7 сая, коронавирусын улмаас комисс ажиллаагүй зэрэг шалтгаанаар 370.1 сая төгрөгийг тус тус санхүүжүүлээгүйтэй холбоотой байна.

Хэрэгжээгүй 141.4 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ хэрэгжих шатандаа байгаа бөгөөд 40.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ газрын маргаан, оршин суугчдын зөрчлийн улмаас хийгдээгүй байна.

2020 онд сумдад 3,848.1 сая төгрөгийг татаасаар олгож, оны эцэст ТЗШ-ийн байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдэл 1,633.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт санхүүжилт

ТЗШ-ийн нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд нийт 3,698.1 сая төгрөг төвлөрснөөс гүйцэтгэлээр 3,490.4 сая төгрөгийг урсгал зардалд, 207.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Зарлагын гүйцэтгэлийн 22.1 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын, 77.9 хувийг орон нутгийн төсвийн байгууллагын зарлага эзэлж байна.

Нэмэлт санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмын хүрээнд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дархан-Уул аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 72 мэдээллээс 61 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид төлбөрийн акт, албан шаардлага өгөгдөөгүй ба 3 зөвлөмжийг биелүүлэн ажилласан байна.

3.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 121 төсвийн байгууллага, 5 төрийн сангийн, 16 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн, нийт 142 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан бөгөөд үүнээс 109 байгууллага дүгнэлт гаргуулж, хувийн 11 сургууль, 17 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс авсан татаас болон аймаг, сумдын ерөнхий орлого, аймгийн Засаг дарга, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансдууд түүвэрт хамрагдсан байна.

Аудитаар Шарын гол сумын “Тулга сувилал” ОНӨААТҮГ-т “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, бусад байгууллагууд “зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 9,915.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 8,780.4

сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,135.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд дараах алдаанууд илэрлээ. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайланд 8,131.0 сая төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн, 390.2 сая төгрөгийн зардлыг бөөн дүнгээр бүртгэсэн, 3.2 сая төгрөгийн хүүний орлогыг буруу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайланд 4.0 сая төгрөгийн орлогыг ангилал зөрүүлэн бүртгэсэн,
- Өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд 252.0 сая төгрөгийн өмчид гарсан өөрчлөлтийг буруу тайлагнасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага байхгүй ба цаашид хэрэгжүүлэх 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 5,108.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснийг аудитын явцад 4,868.9 сая төгрөгийн алдааг залруулж, 239.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 10,421.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 5,940.9 сая төгрөгийн алдааг залруулж, 21.5 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 328.7 сая төгрөгийн зөрчилд 32 албан шаардлага хүргүүлж, 4,130.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 166 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн өмчит 16 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,053.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,602.5 сая төгрөгийн алдааг залруулж, 5.5 сая төгрөгийн зөрчилд 8 төлбөрийн акт тогтоож, 116.7 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 3,328.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 35 зөвлөмж өглөө.

3.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Авлагатай холбоотой асуудал

4.1.1. Илрүүлэлт:

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлан дахь нийт авлагын 33.4 хувь буюу 1,135.2 сая төгрөг нь хугацаа хэтэрсэн байгаа бөгөөд үүнээс 838.9 сая төгрөг нь ОНӨААН-ийн дансны авлага, 278.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн авлага, 16.2 сая төгрөг нь төсөвт байгууллагын дансны авлагын үлдэгдэл байна.

4.1.2. Эрсдэл:

Авлага найдваргүй болж, төсвийн хөрөнгө үрэгдэх, удирдлага болон санхүүгийн ажилтан хариуцлага хүлээх үр дагавартай.

4.1.3. Өгсөн зөвлөмж:

Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулахад анхаарч ажиллахыг байгууллагын удирдлагуудад үүрэг болгож, тодорхой үр дүнд хүргэх.

4.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Холбогдох байгууллагуудад авлага барагдуулах арга хэмжээг авч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллана.

4.2. Шилэн данстай холбоотой асуудал

4.2.1. Илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан “ТЕЗ-ийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт, дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл” зэрэг 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.2.2. Эрсдэл:

Хууль эрхийн акт зөрчигдөх, удирдлага болон санхүүгийн ажилтан хариуцлага хүлээх эрсдэл үүснэ.

4.2.3. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх.

4.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Холбогдох мэргэжилтнүүдэд үүрэг өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллана.

4.3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

4.3.1. Илрүүлэлт:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэврээ тогтоолгон, нэг удаагийн буцалтгүй тусламж авсан ч төрийн албанд ажиллаж байгаа хавсралтад дурдсан 24 байгууллагын 47 албан хаагч байна.

4.3.2. Эрсдэл:

Холбогдох хууль тогтоомж, журам заавар хэрэгжихгүй байх, удирдлага хариуцлага хүлээх эрсдэлтэй.

4.3.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

4.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Холбогдох байгууллагуудад чиглэл өгч, хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 11 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дархан-Уул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			ДАА-2021/01/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дархан-Уул аймгийн ТЕЗ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	МГТ-д үндсэн үйл ажиллагааны орлогын НӨАТ-ыг бусад мөнгөн орлогоор бүртгэсэн.	4.0	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
2	ӨӨТ-д өмчид гарсан өөрчлөлтийг үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралтаар бүртгэсэн.	226.4	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
3	ОҮДТ-д зардлыг бөөн дүнгээр илэрхийлсэн.	390.2	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
4	ОҮДТ-д хүүний орлогыг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.	0.6	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
5	ОҮДТ-д хүүний орлогоор зардлыг бууруулан бүртгэсэн.	2.6	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
6	ОҮДТ-д борлуулалтын өртгийг ангилал зөрүүлэн бүртгэсэн.	6,677.5	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
7	ОҮДТ-д ерөнхий удирдлагын зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн.	1,453.5	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
8	Эздийн өмчийн өөрчлөлтийг орлогоор тайлагнасан.	25.6	Залруулах	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав

9	Нэгтгэсэн тайлан дахь нийт авлагын 33.4 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна.	1,135.2	Зөвлөмж өгөх	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
10	ТЕЗ шилэн дансны нэгдсэн системд 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
11	Орон нутгийн төсвийн 24 байгууллагад төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэврээ тогтоолгон, нэг удаагийн буцалтгүй тусламж авсан ч төрийн албанд ажиллаж байгаа 47 албан хаагч байна.	-	Зөвлөмж өгөх	Засаг дарга, ерөнхий нягтлан бодогч	Б.Азжаргал, Э.Лхагважав
ДҮН		9,915.6			

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2021.04.20